



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 6 сарын 22 өдөр

Дугаар 128

Улаанбаатар хот

Хөдөө аж ахуйн биржийн арилжааны
зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрлийг хүчингүй болгох тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ын 7 дугаар зүйлийн 7.3.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад нэр дурдсан 4 компанийн хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Компанийн оноосон нэрээс “ХААБ” тэмдэглэгээг хасуулж, үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөхийг хавсралтад нэр дурдсан 4 компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгосугай.

3. Нэр бүхий 4 компанийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлт хийж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2017 оны 6 дугаар сарын 22-ны
өдрийн 122 дугаар тогтоолын
хавсралт

УХА0410-5043239

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ХААБ-ЫН ЖАГСААЛТ

№	ХААБ-ын нэрс	Байршил /аймаг/	Тусгай зөвшөөрөл авсан огноо	Түдгэлзүүлсэн огноо /хугацаа/
1.	"Өвөр таван эрдэнийн шим ХААБ" ХХК	Өвөрхангай	2013 оны 3 сарын 13 өдөр	2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 16 дугаар тогтоол /3 сараар/
2.	"Хонгорын таван эрдэнийн хишиг ХААБ" ХХК	Баянхонгор	2013 оны 3 сарын 13 өдөр	
3.	"Батбилгэх ХААБ" ХХК	Дундговь	2013 оны 3 сарын 27 өдөр	
4.	"Хөвчийн тал ХААБ" ХХК	Дорнод	2013 оны 3 сарын 27 өдөр	